

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Улаанбаатар хот

2023 оны ... сарын ...-ний өдөр

“ЭРДЭНЭТ” ТӨҮГ-ЫГ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭН НИЙТ ХУВЬЦААНЫ 20 ХУВИЙГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЖ, 20 ХУВИЙГ ҮНДЭСНИЙ АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭД ХУДАЛДАХ ТУХАЙ

Монгол улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8-ын 5, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны 20 хувийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээс өмнө төрсөн, иргэний бүртгэлд бүртгүүлсэн Монгол Улсын иргэнд тэнцүү хэмжээгээр, үнэ төлбөргүй эзэмшүүлэх;
2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хувьцааны 20 хувийг дотоодын хөрөнгийн биржээр дамжуулан 2023 оны зургадугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй, ажилчдынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах;
3. Энэхүү тогтоолтой холбоотой арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-эрдэнэ/-д даалгасугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Цэрэнпунцаг/-т даалгасугай.

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

Б. ПҮРЭВДОРЖ

**“ЭРДЭНЭТ” ТӨҮГ-ЫГ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХЭЛБЭРТ
ШИЛЖҮҮЛЭН НИЙТ ХУВЬЦААНЫ 20 ХУВИЙГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЖ, 20
ХУВИЙГ ҮНДЭСНИЙ АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭД ХУДАЛДАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1 Хуульзүйн үндэслэл

Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга хүртээмжтэй хуваарилах, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон боловсруулсан болно.

1.2 Практик шаардлага

Нэгдүгээрт, хүн төрөлхтөн дэлхийн хоёрдугаар дайнаас хойш тохиолдоогүй хүнд үеийг туулж байна. Бүтэн гурван жил үргэлжилж байгаа Ковидын цар тахал улс орнуудын эдийн засагт нэн сөргөөр нөлөөлж байна. Мөн Орос-Украины хооронд өрнөсөн дайн улс орнуудын эдийн засаг, санхүүд бодитоор хүндрэл учруулж эхэллээ. Дэлхийн олон оронд инфляцын, Европын улсуудад эрчим хүчний, Хятадад үл хөдлөх хөрөнгийн хямрал нүүрлэлээ. Зээлийн хүрэлцээ эрс багасаж бизнес зогсонги байдалд орсноор хүнс, өргөн хэрэглээний бараа, шатахуун эрчим хүчний үнэ өсөж байна. Улс орнууд цойлсон үнээ хазаарлах, цар тахлын хүнд үед хаалгаа барьсан олон мянган жижиг дунд үйлдвэрлэгчид, хувийн хэвшлээ дэмжих, эдийн засгийн уналтыг зогсоох талаар парламент дээрээ мэтгэлцэж, хямралаас гарах элдэв арга сүвэгчилж байна. Манай орны хувьд ч эдийн засгийн нөхцөл байдал амаргүй байна. Иймээс дээрх нөхцөл байдалд нэн яаралтай дүн шинжилгээ хийж яаралтай арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байгаагийн нэг нь байгалийн баялгаас иргэдэд хүртээх өгөөжийг нэмэгдүүлэх төрийн бодлогоор дамжуулан өрх бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах шаардлага үүсээд байна.

Хоёрдугаарт, Гадаад худалдааны нийт эргэлт 2020 онд 12 875.2 сая ам.доллараас 2022 онд 21 244.8 сая ам.доллар болж огцом өссөн. Үүнээс экспорт 2020 онд 7 576.3 сая ам.доллар байсан бол 2022 онд 12 540.4 сая ам.долларт хүрч огцом өслөө. Гэвч энэ хугацаанд Хэрэглээний үнийн индекс 2.3%-иас 13.2% хүртэл бүхэл 10 пунктаар өссөн. Нэг ам.долларын ханш 2 849 төгрөг байснаа 3431 төгрөг болж чангарсан байна. Хэрэв ийм их хэмжээний валют орж ирсээр байхад яагаад

ам.долларын ханш 20 хувиар суларсан бэ гэдэг асуултад өнгөрсөн оны 9 сард ОУВС анх хариу өгсөн. ОУВС-ын гаргасан тайланд, “Төрийн өмчит компаниуд БНХАУ-ын зарим компанитай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан тул Монгол Улсад орж ирэх байсан экспортын орлого буурсан. Эдгээр нь дэд бүтцийн төслүүд бөгөөд дээрх гэрээ нь улсын нууцад хамаарах тул бид дэлгэрэнгүй мэдээлэлгүй байна. Эндээс мөнгө орж ирнэ гэж хүлээх хэрэггүй болжээ. Мөн эдгээр дэд бүтцийн төслүүд импортыг өсгөнө. Олон нийтэд эдгээр төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлж, яг одоо хэрэгжүүлэх ямар шаардлага байгааг сайтар тайлбарлах шаардлагатай” гэсэн асуудлыг хөндөж тавьсан юм. Өөрөөр хэлбэл төрийн өмчит компаниудын уул уурхайн борлуулалтын валют орж ирээгүй тул ханш өсөж, үнэ өссөн гэсэн дүгнэлт хийсэн. Иймээс энэ асуудалд иргэдийн хяналтыг тавих асуудал зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнийг нийт иргэдэд хувьцаа эзэмшүүлэх замаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Гуравдугаарт, Дэлхийн Банк 2021 онд Монгол улсын хувийн хэвшлийн үйл ажиллагаанд цар тахал хэрхэн нөлөө үзүүлсэн талаар цуврал судалгаа хийсэн.

КОВИД-19 цар тахал нь ААН-үүдийн санхүүгийн хэд хэдэн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж байна. Судалгаанд оролцсон нийт ААН эрхлэгчдийн 82 хувь нь 2020 оны 8-р сард бэлэн мөнгөний хомсдолд орсон байсан бол 2021 оны 2-р сарын байдлаар тус үзүүлэлт 99 хувьд хүрсэн буюу бараг бүх ААН эрхлэгчид цар тахал эхэлснээс хойш бэлэн мөнгөний хомсдолд орсон хэмээн хариулжээ. Тухайлбал, 2020 оны 8-р сарын байдлаар нийт компаниудын 67 хувь нь бэлтгэн нийлүүлэгчдэдээ төлөх төлбөрөө долоо буюу түүнээс дээш хоногоор хойшлуулсан байсан бол 2021 оны 2-р сарын байдлаар энэ үзүүлэлт бараг 90 хувь болж нэмэгдсэн байна. Мөн хугацаанд санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй ААН-үүдийн хувь хэмжээ 27 хувиас 76 хувьд хүрч өссөн байв. Түүгээр ч зогсохгүй, тэдний санхүүгийн ирээдүйн ачааллын талаарх хүлээлт ч мөн адил дордож, бизнес эрхлэгчдийн 89 хувь нь цаашдаа өр төлбөрөө хугацаанд нь төлөх боломжгүй болно гэсэн төсөөлөлтэй байна. Иймээс Монголын олон аж ахуйн нэгжүүд үүдээ хаах, ажиллагсдаа цомтгох, эсхүл үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх зэрэг амаргүй шийдвэрүүдийг гаргахад хүрч байсан гэсэн дүгнэлтэд хүрч байв. Энэ байдал өнөөдрийг хүртэл олигтой сайжирсангүй. Иймээс аж ахуй нэгжүүдээ төрөөс тодорхой хэмжээнд дэмжих шаардлагатай байна.

Дөрөвдүгээрт, “Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд” тайланд дурдсанаар эдгээр компаниуд 2021 оны жилийн эцсийн байдлаар 53,482 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 10,649 тэрбум төгрөгийн орлого олж, 1,35 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан үзүүлэлттэй гарчээ. Мөн төрийн өмчит компаниуд 2011 онд 4 их наяд төгрөгийн хөрөнгөтэй байсан бол 2021 онд 53 их наяд төгрөгөөр хөрөнгөтэй болжээ. Эсрэгээрээ тэдний өр 18 их наяд хүрчээ. Иймээс төрийн өмчит компаниудын менежментийг сайжруулах ёстой. Учир нь төрийн өмчит компаниуд өр үйлдвэрлэж байна. 2021 оны байдлаар Дэлхийн банкны гаргасан судалгаагаар төрийн өмчит компаниудын хөрөнгийн өгөөжийг "тэг" хувь гэж үнэлсэн. Ашигт ажиллагаа ердөө 5,9% байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэт” ТӨҮГ-аас бусад

нь ерөнхий дүнгээрээ 4%-ийн алдагдалтай гарчээ. Мөн Эрдэнэт ТӨҮГ-ын өр 5 орчим ихнаяд төгрөгт хүрсэн мэдээ байдаг. Иймээс төрийн өмчит компаниудын хувьцааг нийтэд эзэмшүүлэх замаар ашигтай ажиллагааг сайжруулах шаардлагатай байгаа юм.

Дээр дурдсан бүхнээс харвал төр, аж ахуйн ажилтай хутгалдах нь ямар нэгэн үр дүнгүй байдгийг харуулж байна. Өмч эзэнтэй болсноор элдэв хулгай, үрэлгэн байдал үгүй болох учраас тогтолцооны томоохон өөрчлөлт хийх цаг нь болсон байна. Дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Эрдэнэт” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн нийт хувьцааны 20 хувийг иргэдэд, 20 хувийг үндэсний аж ахуй нэгжүүдэд эзэмшүүлэх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэхээр өргөн барилаа.

Хоёр. Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

“Эрдэнэт” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн нийт хувьцааны 20 хувийг иргэдэд эзэмшүүлж, 20 хувийг үндэсний аж ахуй нэгжүүдэд худалдах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 4 зүйлтэй байх бөгөөд төсөлд дараах асуудлыг тусгасан болно. Үүнд:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны 20 хувийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон түүнээс өмнө төрсөн, иргэний бүртгэлд бүртгүүлсэн Монгол Улсын иргэнд тэнцүү хэмжээгээр, үнэ төлбөргүй эзэмшүүлэх;
2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хувьцааны 20 хувийг дотоодын хөрөнгийн биржээр дамжуулан 2023 оны зургадугаар сарын 30-ны өдөр ба түүнээс өмнө улсын бүртгэлд бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон татварын өр төлбөргүй, ажилчдынхаа нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлсөн үндэсний аж ахуйн нэгжүүдэд адил тэнцүү хэмжээгээр, нэрлэсэн үнээр худалдах;
3. Энэхүү тогтоолтой холбоотой арга хэмжээ авч, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л. Оюун-эрдэнэ/-д даалгасугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц. Цэрэнпунцаг/-т даалгасугай.

Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

“Эрдэнэт” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн нийт хувьцааны 20 хувийг иргэдэд эзэмшүүлж, 20 хувийг үндэсний аж ахуй нэгжүүдэд худалдах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн эерэг үр дагавар үүснэ гэж үзэж байна:

1. Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга хүртээмжтэй хуваарилснаар ил тод байдал хангагдаж, олон нийтийн хяналт оролцоо нэмэгдэж үүсээд байгаа элдэв хулгай, үрэлгэн байдал үгүй болох боломж нээгдэнэ.
2. Энэхүү хувьцаа нь иргэдийн амьдралд санхүүгийн баталгаа болно.
3. Иргэд ногдол ашгаараа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, улмаар санхүүгийн боломж бий болсноор ажлын байр шинээр нэмэгдэх, хүн амын амьжиргааны түвшин дээшлэх бөгөөд иргэдийн амьдрах орчин, нөхцөл сайжирна.
4. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим бодитоор биелж уул уурхайн баялгийн үр өгөөжийн дийлэнхийг ард түмэн хүртэх эрх зүйн үндэслэл тавигдана.
5. Ковидын цар тахалд нэрвэгдсэн олон мянган аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд бодит үр дүнтэй дэмжлэг болно.
6. Байгалийн баялгаа ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажна.
7. Төрийн өмчит компаниудын үйл ажиллагаанд хяналтын тогтолцоог шинэ шатанд гарснаар төсвийн орлого нэмэгдэнэ.
8. Валютын урсгал нэмэгдэж төсвийн орлого сайжирснаар хэрэглээний үнийн түвшин буурна.

Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал:

“Эрдэнэт” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн нийт хувьцааны 20 хувийг иргэдэд эзэмшүүлж, 20 хувийг үндэсний аж ахуй нэгжүүдэд худалдах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиуд, Улсын Их Хурлын холбогдох тогтоолуудтай нийцсэн болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын хуулиуд болон Улсын Их хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт орохгүй болно.

ТАНИЛЦУУЛГА

2023.06.23

Улаанбаатар хот

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь зэс, молибдены хүдрийн олборлолт, баяжуулалтаар Ази тивдээ томоохонд тооцогддог үйлдвэр бөгөөд жилд 37 сая тонн хүдэр олборлон, 32.5 сая тонн хүдэр боловсруулж 580.0 орчим мянган тонн зэсийн баяжмал, 5.0 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг.

1972 онд "Эрдэнэтийн-Овоо"-ны зэс, молибдены ордыг эзэмших Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ батлагдсан ба 1973 оны 02 дугаар сарын 20-нд уг ордыг ашиглах талаар /хуучин нэрээр/ БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газрын хооронд түүхэн хэлэлцээр байгуулагдсан.

Монгол-Зөвлөлтийн хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэр /хуучин нэрээр/ нь БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1973 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хэлэлцээрийн дагуу анх 50:50 хувийн эзэмшилтэйгээр байгуулагдаж, 1978 оны 12 дугаар сарын 14-нд анхны баяжмалаа гаргаснаар үйл ажиллагаагаа эхэлсэн тэр үеэс ХХ зууны Монгол Улсын хамгийн том бүтээн байгуулалт болох Эрдэнэт үйлдвэрийн түүх эхэлсэн төдийгүй уул уурхай дагасан, иж бүрэн дэд бүтэц бүхий Эрдэнэт хотыг цогцоор нь бүтээн босгосон нь уул уурхайн томоохон төслийн сонгодог загвар болсон юм.

"Эрдэнэт" үйлдвэр нь хоёр улсын Засгийн газар хоорондын 1991 оны хэлэлцээрийн дагуу 51:49 хувийн эзэмшилтэй хамтарсан үйлдвэр, 2003 оны хэлэлцээрийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/-ийн хэлбэрээр ажиллаж байгаад 2016 оны 06 дугаар сард ОХУ-ын "Ростех" корпораци өөрийн эзэмшлийн 49 хувийг худалдсанаар Монгол Улсын Засгийн газар 51 хувийг, "Монголиан коппер корпорейшн" ХХК 49 хувийг эзэмшиж байв. Монгол Улсын Засгийн газар 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр тогтоол гаргаж, "Эрдэнэт үйлдвэр"-ийг Төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилсөн.

"Эрдэнэт үйлдвэр" ойролцоогоор экспортын орлогын 10 хувийг эзэлдэг, жилд дунджаар төсвийн орлого бүрдүүлэхэд нэг их наяд гаруй төгрөг төвлөрүүлдэг. Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар дараах дөрвөн өөрчлөлт гарна гэж үзэж байна. Үүнд:

НЭГ: Аливаа улсын иргэд ажилтай, орлоготой, боловсролтой, эрүүл саруул, амьдрал ахуй хүрэлцээтэй хангалуун байх тохиолдолд төр нь тогтвортой, улс нийгэм нь хөгжих үндэс суурь тавигджээ гэж тодорхойлдог.

Үндсэн хуулийн 6.2-д байдаг нэгэн заалт өнөөдрийг хүртэл биеллээ олохгүй маш олон асуулт дагуулж ирлээ. "Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" гэх заалт хэрэгжих суурь тавигдаж, цаашид бусад стратегийн чухал ордууд дээр энэхүү загвар хэрэгжих боломжийг нээж өгөх юм.

ХОЁР: Цар тахлын хүнд жилүүдэд олон их наядын хөтөлбөрүүд хэрэгжсэн хэдий ч үр дүн тааруу байсныг хаалгаа барьсан олон зуун аж ахуй нэгж, ажилгүй, орлогогүй ядуусын эгнээ өргөжсөн зэргээс харж болно. Үндэсний статистикийн гаргасан тооцооллоор Монгол улсын нийт ажиллагчдын тоо 2019 оны 4-р улиралд 1,188,439 байсан бол 2023 оны 1 дүгээр улирлын дүнгээр 1,111,257 болж 77 мянга 182 хүнээр цөөрчээ. 2019 онд манай улсын ЖДҮ-ийн нийт экспорт ДНБ-ний 2.9%, импорт 23.6% эзэлж байсан бол 2021 онд экспорт 2.4%, импорт нь 13.7% болж огцом буурчээ. ЖДҮ эрхлэгчдийн ДНБ-д эзлэх хувь 2020 онд 5.6%, 2021 онд 5.5% төдий эргэлдэж байна. Гэтэл энэ үзүүлэлтүүд хөгжингүй орнууд, Хятад, АНУ-д ДНБ-нийх нь 60 хүртэл хувийг эзэлдэг. Ийм болохоор ид ажиллах насны залуучууд гадаад руу бөөнөөрөө тэмүүлж, Монгол улсын 3 иргэн тутмын 2 нь ажилгүй, орлогогүй үзүүлэлтэд дөхөж очжээ. Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчдын тоо 2019 оны 12 сард 982,351 байсан бол 2023 оны 4 сарын мэдээгээр 852,494 болж буурчээ. Өнөөдөр хувийн хэвшилд бага хүүтэй зээл, санхүүгийн дэмжлэг юу юунаас чухал байгаа. Монголбанкны бодлогын хүү 13 хувьд хүрснээр аж ахуй нэгжүүдийн зээл үндсэндээ зогсож бизнес царцсан үед энэхүү УИХ-ын тогтоолын төсөл батлагдсанаар аж ахуй нэгжүүдэд бодит дэмжлэг болж шинээр олон зуун мянган аж ахуй нэгж байгуулагдан ажиллагчдын тоо эрс өсөх тооцоо хийлээ.

ГУРАВ: Төрийн үндсэн үүрэг төсөв, мөнгөний бодлого ямар хэмжээнд байгааг үнийн өсөлт, төгрөгийн ханшийн сулралаар хэмждэг. Инфляц гуравдах жилдээ хоёр оронтой тоонд үргэлжилж өрхийн бодит орлого буурсаар байна. Монгол улс дундаж давхаргагүй Африк, Латин Америкын буурай орнуудын эгнээ рүү эрчимтэй алхаж эхэллээ. Инфляц өрхийн орлогоос 14 их наяд төгрөг “хумсалсан” гэж Монголбанкны удирдлага УИХ-ын Эдийн Засгийн Байнгын Хорооны хурал дээр мэдэгдсэн.

Аливаа Засгийн газар энгийн, ойлгомжтой байж бизнесийн болон аж ахуйн үйл ажиллагаанд хутгалдахгүй байсан тохиолдолд эдийн засгийн макро үзүүлэлтүүд тодорхой хугацааны дараа тогтворждог. Энэхүү тогтоолын төсөл Засгийн газрын үйл ажиллагааг тодорхой болгож үнийн хөөрөгдөл, үндэсний валютын ханш сулрах асуудлыг шийдвэрлэх боломж нээж байгаа юм.

ДӨРӨВ: Дэлхийн улс орнууд төсөв санхүү, мөнгөний бодлогоо чамбайруулж гадаад хямралыг даван туулах бүхий л арга замаа эрэлхийлж парламентийн түвшиндээ эдийн засгийн “зөөлөн буулт”-ын бодлогын талаар ид мэтгэлцэж байна. Харин манай эрх баригчдын хувьд Төсвийн хөрөнгө оруулалт, Засгийн газрын тусгай тусгай сан, Хөгжлийн банк, төмөр замын тээвэр, нүүрсний борлуулалттай холбоотой ихнаядаар хэмжигдэх асуудалд хутгалдсан. Энэхүү тогтоолын төсөл батлагдвал төрийн өмчид аж ахуй нэгжид төр буюу ялсан намыхан биш Монголын ард түмэн, үндэсний нийт аж ахуй нэгжүүдийн төлөөлөл Төлөөлөн Удирдах Зөвлөлд орж хяналт тавих бүрэн боломж нээгдэж байна.

**“ЭРДЭНЭТ” ТӨҮГ-ЫГ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХЭЛБЭРТ
ШИЛЖҮҮЛЭН НИЙТ ХУВЬЦААНЫ 20 ХУВИЙГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЖ, 20
ХУВИЙГ ҮНДЭСНИЙ АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭД ХУДАЛДАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН**

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аливаа улсын иргэд ажилтай, орлоготой, боловсролтой, эрүүл саруул, амьдрал ахуй хүрэлцээтэй хангалуун байх тохиолдолд төр нь тогтвортой, улс нийгэм нь хөгжих үндэс суурь тавигджээ гэж тодорхойлж болдог.

Үндсэн хуулийн 6.2-д байдаг нэгэн заалт өнөөдрийг хүртэл биеллээ олохгүй маш олон асуулт дагуулж ирлээ. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэх заалт огт хэрэгжихгүй байна.

Цар тахлын хүнд жилүүдэд олон их наядын хөтөлбөрүүд хэрэгжсэн хэдий ч үр дүн тааруу байсныг хаалгаа барьсан олон зуун аж ахуй нэгж, ажилгүй, орлогогүй ядуусын эгнээ өргөжсөн зэргээс харж болно. Өнөөдөр Монголбанкны бодлогын хүү 13 хувьд хүрснээр аж ахуй нэгжүүдийн зээл үндсэндээ зогсож бизнес царцсан үед энэхүү УИХ-ын тогтоолын төсөл батлагдсанаар аж ахуй нэгжүүдэд бодит дэмжлэг болж шинээр олон зуун мянган аж ахуй нэгж байгуулагдан ажиллагчдын тоо эрс өсөх тооцоо хийлээ.

Ийнхүү газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд болон үндэсний аж ахуй нэгжүүдэд дэмжих, тэгш, шударга хүртээмжтэй хуваарилах, ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эрдэнэт” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн нийт хувьцааны 20 хувийг иргэдэд эзэмшүүлж, 20 хувийг үндэсний аж ахуй нэгжүүдэд худалдах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэхээр өргөн барилаа.

**УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж. Батсуурь, А. Адъяасүрэн нарын санаачлан боловсруулсан “Эрдэнэт” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн нийт хувьцааны 20 хувийг иргэдэд эзэмшүүлж, 20 хувийг үндэсний аж

ахуй нэгжүүдэд худалдах тухай” Монгол Улсын Их хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу судалсан болно.

Энэхүү УИХ-ын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон олон улсын гэрээнд харшлаагүй нийцэж байгаа болно..

ХОЁР. АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН

НЭГ: Аливаа улсын иргэд ажилтай, орлоготой, боловсролтой, эрүүл саруул, амьдрал ахуй хүрэлцээтэй хангалуун байх тохиолдолд төр нь тогтвортой, улс нийгэм нь хөгжих үндэс суурь тавигджээ гэж тодорхойлж болдог.

Үндсэн хуулийн 6.2-д байдаг нэгэн заалт өнөөдрийг хүртэл биеллээ олохгүй маш олон асуулт дагуулж ирлээ. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэх заалт хэрэгжихгүй байна.

ХОЁР: Цар тахлын хүнд жилүүдэд олон их наядын хөтөлбөрүүд хэрэгжсэн хэдий ч үр дүн тааруу байсныг хаалгаа барьсан олон зуун аж ахуй нэгж, ажилгүй, орлогогүй ядуусын эгнээ өргөжсөн зэргээс харж болно. Үндэсний статистикийн гаргасан тооцооллоор Монгол улсын нийт ажиллагчдын тоо 2019 оны 4-р улиралд 1,188,439 байсан бол 2023 оны 1 дүгээр улирлын дүнгээр 1,111,257 болж 77 мянга 182 хүнээр цөөрчээ. 2019 онд манай улсын ЖДҮ-ийн нийт экспорт ДНБ-ний 2.9%, импорт 23.6% эзэлж байсан бол 2021 онд экспорт 2.4%, импорт нь 13.7% болж огцом буурчээ. ЖДҮ эрхлэгчдийн ДНБ-д эзлэх хувь 2020 онд 5.6%, 2021 онд 5.5% төдий эргэлдэж байна. Гэтэл энэ үзүүлэлтүүд хөгжингүй орнууд, Хятад, АНУ-д ДНБ-нийх нь 60 хүртэл хувийг эзэлдэг. Ийм болохоор ид ажиллах насны залуучууд гадаад руу бөөнөөрөө тэмүүлж, Монгол улсын 3 иргэн тутмын 2 нь ажилгүй, орлогогүй үзүүлэлтэд дөхөж очжээ. Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчдын тоо 2019 оны 12 сард 982,351 байсан бол 2023 оны 4 сарын мэдээгээр 852,494 болж буурчээ. Иймээс аж ахуй нэгжүүдэд бодит дэмжлэг болж шинээр олон зуун мянган аж ахуй нэгж байгуулах ажиллагчдын тоо эрс өсгөх шаардлагатай байна.

ГУРАВ: Төрийн үндсэн үүрэг төсөв, мөнгөний бодлого ямар хэмжээнд байгааг үнийн өсөлт, төгрөгийн ханшийн сулралаар хэмждэг. Инфляц гуравдах жилдээ хоёр оронтой тоонд үргэлжилж өрхийн бодит орлого буурсаар байна.

Аливаа Засгийн газар энгийн, ойлгомжтой байж бизнесийн болон аж ахуйн үйл ажиллагаанд хутгалдахгүй байсан тохиолдолд эдийн засгийн макро үзүүлэлтүүд тодорхой хугацааны дараа тогтворждог. Иймд Засгийн газрын үйл ажиллагааг тодорхой болгож үнийн хөөрөгдөл, үндэсний валютын ханш сулрах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа юм.

ДӨРӨВ: Монгол улсын эрх баригчдын хувьд Төсвийн хөрөнгө оруулалт, Засгийн газрын тусгай тусгай сан, Хөгжлийн банк, төмөр замын тээвэр, нүүрсний борлуулалттай холбоотой ихнаядаар хэмжигдэх асуудалд хутгалдсан. Иймд төрийн өмчид аж ахуй нэгжид ялсан намыхан биш Монголын ард түмэн, үндэсний нийт аж ахуй нэгжүүдийн төлөөлөл Төлөөлөн Удирдах Зөвлөлд орж хяналт тавих шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол улсын эдийн засаг уул уурхайгаас хараат бөгөөд Ковидын өнгөрсөн хоёр жилийн хүндрэл, ОХУ болон Украин хоорондын дайн, дэлхийн тэргүүлэх чиглэлийн орнуудын ковидын дараах төсөв, мөнгөний бодлого эрс өөрчлөгдсөнтэй холбоотой манай улсын эдийн засагт багагүй хүндрэл үүссэн. Мөн үнэ өсөж сүүлийн 21 сар инфляц хоёр оронтой тооноос доош буусангүй. Иймээс иргэдийн амьдралд тодорхой хэмжээний дэм үзүүлэх нөгөө талаас уул уурхайн бүтээгдэхүүний экспорттой холбоотой “хулгай”-н болон Төрийн өмчит компаниудын замбараагүй зарцуулалтад хяналт тавихад иргэд болон хувийн аж ахуй нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх замаар хяналтын тогтолцоог шинэ шатанд гаргана.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-д заасан асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг нь харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийснээр,	Иргэд болон хувийн аж ахуй нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх замаар хяналтын тогтолцоог шинэ шатанд гаргах хууль эрхзүйн үндэс бүрдэнэ.	Байгалийн баялгаа ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажна.
2	УИХ-ын тогтоолын төсөл боловсруулж батлуулснаар,	Үр дүнд эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа өнөө үед өрхийн орлого нэмэгдэнэ.	Гадаадын хөрөнгө оруулалт, төр хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтыг ашиглах боломж нээгдэнэ.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг арилгахын тулд авч буй түр, тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм		Олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцсэн
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм		Шударга ёсны зарчимд нийцнэ
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглэж байна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	Уг асуудалтай ямар нэгэн холбоо байхгүй.

2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх		Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		Үгүй	Шаардлагагүй гэж тооцов.
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм		Хил дамнасан хөрөнгө оруулалт эрс нэмэгдэнэ.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөлөлд урьдчилан арга хэмжээ авах тогтолцоо бий болно.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Өрсөлдөөн зах зээлийн хуулиар явагдах болно.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй, эсрэгээрээ шударга өрсөлдөх боломж нээгдэнэ.

	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Монополийг задлах үйл ажиллагаа явагдана.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Хяналттай болсноор зардал огцом буурна.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Санхүүжилт босгох боломж нэмэгдэнэ.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ийм асуудал гарахгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Хязгаарлалт, хоригийн асуудал гарахгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Аж ахуй нэгжийн үйл ажиллагаа эрчимжинэ.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Нэмэлт зардал гарахгүй, эсрэгээрээ зардлууд буурна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ийм зохицуулалт хийх шаардлага гарахгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ийм зохицуулалт хийх шаардлага гарахгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ийм зохицуулалт хийх шаардлага гарахгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Валютын урсгал нэмэгдэж төсвийн орлого сайжирснаар хэрэглээний үнийн түвшин буурна.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Өрхийн санхүүгийн байдалд эерэгээр нөлөөлнө.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		Худалдаа, үйлчилгээний ажлын байр нэмэгдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ийм сөрөг нөлөө гарахгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн тоо өснө.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Улсын төсвийн орлого нэмэгдэнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Ийм өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдал сайжирна.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Хөрөнгө оруулалтын нөхцөл сайжирч, зах зээлийн тогтвортой байдал нэмэгдэнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Эсрэгээрээ инфляц буурна.

11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.
------------------------	--	------	--	--

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	тийм		Шууд биш ажлын байр маш олноор нэмэгдэнэ
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ажлын байрны цомхотгол байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо эрс нэмэгдэнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Нөлөөлөхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	Ажлын чанар, стандартад нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	Шинээр ажлын стандарт гаргах шаардлагагүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	Ажлын байранд ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Засаглалын харилцаанд оролцогчдод ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Огт нөлөөлөхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Огт нөлөөлөхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг өөрчлөлт гарахгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө гарахгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

**“ЭРДЭНЭТ” ТӨҮГ-ЫГ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХЭЛБЭРТ
ШИЛЖҮҮЛЭН НИЙТ ХУВЬЦААНЫ 20 ХУВИЙГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЖ, 20
ХУВИЙГ ҮНДЭСНИЙ АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭД ХУДАЛДАХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ
ҮНЭЛСЭН ТАЙЛАН**

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж. Батсуурь, А. Адъяасүрэн нарын санаачлан боловсруулсан “Эрдэнэт” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн нийт хувьцааны 20 хувийг иргэдэд эзэмшүүлж, 20 хувийг үндэсний аж ахуй нэгжүүдэд худалдах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн /цаашид “Тогтоолын төсөл” гэх/ зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д /цаашид “аргачлал” гэх/ заасны дагуу хийлээ.

**ХОЁР. ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ тогтоолын төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд заасны дагуу 6 шалгуур үзүүлэлтээс 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал

¹Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

“Зорилгод дүн шинжилгээ хийх” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээ тухайн хуулийн төсөлд тавьсан зорилгыг биелүүлэхэд чиглэсэн эсэх, зорилгод хүрэх байдалд дүн шинжилгээ хийлээ. Мөн салбарын мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, тухайн асуудалтай холбоотойгоор бусад орнуудын туршлагыг судалсан болно.

“Практикт турших” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийг практикт турших нь тухайн хуулийн төсөл хэрэгжих боломжтой байна уу, хуулийг хэрэгжүүлэх байгууллагууд түүнийг хүлээн зөвшөөрч байна уу, бусад этгээдэд хэрхэн нөлөөлж байгаа болон тухайн зохицуулалтын хийдэл, зөрчлийг тогтооход чухал ач холбогдолтой арга хэмжээ боловч практикт туршилт хийх нь ихээхэн хугацаа, хүн хүч, зардал шаарддаг тул ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа “Эрдэнэс Тавантолгой” ХК зэрэг хувьцаат компаниудын үйл ажиллагаа, тухайн хуулийн төслийн зохицуулалтад тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэх гадаадын практик жишээнээс үлгэрлэн авсан болно.

“Ойлгомжтой байдлыг шалгах” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томъёологдсон эсэхийг шалгаж тогтоосон болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэл, хэрэгцээ шаардлагад тогтоолын төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс тогтоолын төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон тогтоолын төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийв.

“Практикт турших” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийг практикт турших нь тухайн хуулийн төсөл хэрэгжих боломж байгаа эсэхийг тодорхойлсон болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тогтоолын төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд тогтоолын төслийг бүхэлд нь сонгон авлаа.

ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар авч үзэв.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Тогтоолын төсөл бүхэлдээ	Дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	Тогтоолын төсөл бүхэлдээ	“Эрдэнэс Тавантолгой” ХК зэрэг хувьцаат компаниудын үйл ажиллагаа, тухайн хуулийн төслийн зохицуулалтад тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэх гадаадын практик жишээнээс үлгэрлэн авсан болно.
3	Ойлгомжтой байдал	Тогтоолын төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар <u>ойлгомжтой</u> байдлыг шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу тогтоолын төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Үнэлгээ хийхээр сонгож авсан зохицуулалтын хувьд тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагад нийцэж, тогтоолын төслийн зорилтыг хангах боломжтой байна. Хэдийгээр төр засгаас тодорхой арга хэмжээ авч ирсэн боловч өнөөг хүртэл “Эрдэнэт” ТӨҮГ-тай холбоотой ашиггүй үйл ажиллагаа, хэт их зардал орсон худалдан авалт, тус компанийн үйл ажиллагаанд огт хамааралгүй гэрээ, дэлхийн зах зээлийн үнээс хэт бага үнэтэй зэсийн баяжмал нийлүүлэх гэрээ зэрэгтэй холбоотой одоо ч эрдэс бүтээгдэхүүнийхээ экспортын хэмжээг нэмэгдүүлж чадахгүй байна. Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар тус компанийн үйл ажиллагаа олон нийтийн хяналтад орж, экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэх, элдэв зардлууд огцом буурч компани ашигтай ажиллах боломж гарч ирнэ.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу ОХУ, Казахстан зэрэг орнуудын БНХАУ руу хийж буй түүхий эдийн статистик тооцоолол туршлагыг судалсан болно. Мөн “Эрдэнэс Тавантолгой” болон “Оюу толгой” ХК зэрэг ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үйл ажиллагааны сайн жишээнээс үлгэрлэн авсан болно. Тухайн тогтоолын төсөл батлагдсанаар практикт хэрэгжих боломжгүй ямар нэгэн асуудал гарахгүй болно.

“Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараахь асуултад хариулт өгөх замаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан.

29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагагүй.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагагүй.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

ТАВ.ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

5.1.Баримтжуулалт

Тогтоолын төслийн үр нөлөөг үнэлэхэд ашигласан дараах баримт бичиг, мэдээлэл, тоо баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд баримтжуулж хавсаргалаа.

1. Хүний хөгжил сангийн тухай хууль
2. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
5. УИХ-ын тогтоол (2010 оны 7 сарын 7-ны өдрийн 39 дугаар, 2011 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 57 дугаар)
6. Судалгаа

5.2. Дүгнэлт

Улсын Их Хурлын тогтоолын төслийн зохицуулалт нь тогтоолын төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн бусад зохицуулалтуудыг хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийлээ.

Тогтоолын төсөл нь үзэл баримтлал болон энэхүү тогтоолын төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлагатай нийцэж байгаа нь зорилгод хүрэх, ойлгомтой байх, бусад хууль тогтоомжтой нийцсэн, давхардалгүй, зөрчилгүй томъёологдсон байна.

**“ЭРДЭНЭТ” ТӨҮГ-ЫГ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХЭЛБЭРТ
ШИЛЖҮҮЛЭН НИЙТ ХУВЬЦААНЫ 20 ХУВИЙГ ИРГЭДЭД ЭЗЭМШҮҮЛЖ, 20
ХУВИЙГ ҮНДЭСНИЙ АЖ АХУЙ НЭГЖҮҮДЭД ХУДАЛДАХ ТУХАЙ МОНГОЛ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ
ТАЙЛАН**

“Эрдэнэт” ТӨҮГ-ыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн нийт хувьцааны 20 хувийг иргэдэд эзэмшүүлж, 20 хувийг үндэсний аж ахуй нэгжүүдэд худалдах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталснаар төсвөөс ямар нэгэн зардал гарахгүй бөгөөд дараах ач холбогдолтой байх юм. Үүнд:

1. Улсын төсөвт үндэсний аж ахуй нэгжүүдээс ойролцоогоор 300 орчим сая ам.долларын орлого орно.
2. Ковидын дараах эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлж улс орнуудад нөлөөлж болох эдийн засгийн хямралыг даван туулахад зохих үр дүнгээ өгнө.
3. Нийт иргэдийн оролцоог хангасан хяналтын тогтолцоог шинэ шатанд гаргаснаар тус компанийн үйл ажиллагаа эрчимжиж уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт, тээвэрлэлтийн зардал, хугацаа хэмнэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар нэмэгдэнэ. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тогтвортой өсөн нэмэгдсэнээр төсвийн орлого тогтворжиж, эдийн засагт эерэг үр дагавар үзүүлнэ.
4. Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэнд тэгш, шударга хүртээмжтэй хувиарлагдаж, ил тод байдал хангагдаж, олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлснээр үүсээд байгаа элдэв асуудлыг шийдвэрлэнэ.
5. Иргэд ногдол ашгаараа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх санхүүгийн боломж гарснаар ажлын байр шинээр нэмэгдэх, хүн амын амьжиргааны түвшин дээшлэх бөгөөд иргэдийн амьдрах орчин, нөхцөл сайжирна.
6. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчим бодитоор биелж уул уурхайн баялгийн үр өгөөжийн дийлэнхийг ард түмэн хүртэх эрх зүйн үндэслэл тавигдана.
7. Байгалийн баялгаа ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажна.
8. Валютын урсгал нэмэгдэж төсвийн орлого сайжирснаар хэрэглээний үнийн түвшин буурна.